



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/399

Ховд

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох, сунгах, түр түтгэлзүүлэх, цуцлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19 дүгээр зүйлийн 19.17.1, 19 дүгээр зүйлийн 19.20.2, 19 дүгээр зүйлийн 19.21 дэх заалтууд, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон 2 дугаар зэрэглэлийн “Цэлмэг ирээдүй”, “Марал” эмийн санд 1 жилийн хугацаатайгаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Дуут сумын Эрүүл мэндийн төв, зүрх судас, дотор, лабораторын тусламж үйлчилгээ үзүүлэх “Мөнхцохилохуй”, шүдний эмчилгээ, согог, гажиг засал, мэс заслын “Хаш сондор”, 2 дугаар зэрэглэлийн “Тунгалаг тун” эмийн сангуудын мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 5, Эрдэнэбүрэн сумын 2 дугаар зэрэглэлийн эмийн сан, дотрын “Элэг энэрэл” үүдэн эмнэлэг, “Танан шигтгээ” хиймэл шүдний эмнэлгүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилээр тус тус сунгасугай.

3. Эмэгтэйчүүдийн оношилгоо эмчилгээ үзүүлэх “Эх үр” эмнэлгийг өөр хүнд шилжүүлэхээр ирүүлсэн бичиг баримт нь шаардлага хангахгүй, гэрээ хийгдээгүй, ажиллах хүний санал тодорхойгүй тул үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 3 сараар түтгэлзүүлж, сүүлийн зургаан сарын дотор үйл ажиллагаагаа

явуулаагүй эмэгтэйчүүдийн оношилгоо эмчилгээний “Ургийн өргөө” хувийн эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг цуцалсугай.

4. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, түтгэлзүүлсэн, цуцалсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, оношилгоо эмчилгээний тусламж үйлчилгээний шинэ төрөл техник, технологи, бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжиж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Д.Оюунцэцэг/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ